



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ҮҮРИЙНТУЯА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД**

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: letter@moe.gov.mn,
Цахим хуудас: www.moe.gov.mn

2025.06.06 № 1/2564

танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Таны 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 20 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн талаар” гэсэн асуулгатай танилцаж доорх хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам”-ыг Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор шинэчлэн баталснаар Таны асуулгад дурдсан 102 дугаар тогтоолыг хүчингүй болгосон. Энэхүү шинэчлэн батлагдсан журмын 9 дүгээр зүйлд Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит сургалтын байгууллагын суралцагчид сургалтын төлбөрийн 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг тусгаж өгсөн ба уг хөнгөлөлтийг “Дээд боловсролын тухай” хуулийн 4.1.7-д “Сургалтын төлбөрийн хөнгөлөлт гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн сурлагын амжилт, төлбөрийн чадамжийг тооцож төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөхийг” гэж тодорхойлсон;

2. Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ.” гэж заасны дагуу тус тэтгэлгийн сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний хөнгөлөлт үзүүлэх санхүүжилтэд 2022-2024 онд нийт 7,346 суралцагчид 11.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор батлагдсан журамд тэтгэлэг, хөнгөлөлт эдлэх суралцагч нь магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр суралцана гэж заасны дагуу 2024 онд 1,853 суралцагчид 3.2 тэрбум төгрөгийг зарцуулсан. Тус тэтгэлэг нь хэрэгжиж эхэлсэн хугацаанаас хойш тусгайлан төсөв хянагдаж батлагдаагүй бөгөөд уг зардлыг Боловсролын зээлийн сангийн хэмнэгдсэн зардлаас санхүүжүүлж ирсэн. 2025 оны төсвийн хувьд “Орон нутгийн их, дээд сургуульд суралцагчийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт” зориулалтаар 4,983,100.7 мянган төгрөг батлагдан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

П.НАРАНБАЯР



14256 1144